



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 733

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой, 17 нэрийн, нийт 60,835,563.65 (жаран сая найман зуун гучин таван мянга таван зуун жаран гурван төгрөг жаран таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 18,250,669.10 (арван найман сая хоёр зуун тавин мянга зургаан зуун жаран есөн төгрөг арван мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Г.Гансүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007207
35-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 4 дугаар сарын 8-ны өдрийн
733 дугаар тогтоолын хавсралт

**"ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ" ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГҮЙ, АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАЖ
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтанд орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ /хуриутлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа /жилээр/
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт үнэ (төгрөг)	
1	Амьсгалах, хамгаалах клапан	2010/05/27	20,831,000.00	1	20,831,000.00	6,249,300.00	1	6,249,300.00	5
2	Шатахууны насос /дугуйтай/	2018/10/25	3,500,000.00	1	3,500,000.00	1,050,000.00	1	1,050,000.00	5
3	Гар станц Telt N60	2021/05/13	118,181.82	7	827,272.74	35,454.55	7	248,181.82	1
4	Гар утас /хар, андройд/	2021/06/14	380,000.00	2	760,000.00	114,000.00	2	228,000.00	2
5	Кондейшн	2019/03/15	1,200,000.00	1	1,200,000.00	360,000.00	1	360,000.00	2
6	Шкаф	2016/04/04	145,000.00	1	145,000.00	43,500.00	1	43,500.00	2
7	Лабораторийн тусгай зориулалтын тавилга	2017/12/12	2,680,000.00	2	5,360,000.00	804,000.00	2	1,608,000.00	5
8	Лабораторийн тусгай зориулалтын тавилга /тумбочка/	2017/12/12	160,000.00	2	320,000.00	48,000.00	2	96,000.00	5
9	Шкаф /хувцасны/	2017/12/12	280,000.00	1	280,000.00	84,000.00	1	84,000.00	3
10	Хогийн бункер	2017/12/20	2,400,000.00	1	2,400,000.00	720,000.00	1	720,000.00	5
11	Халаагч /печь/	2018/03/14	200,000.00	1	200,000.00	60,000.00	1	60,000.00	2
12	Суурин компьютер	2019/03/25	1,989,800.00	4	7,959,200.00	596,940.00	4	2,387,760.00	2
13	Компьютер /суурин, Dell optiplex 3080MT i5, /	2021/03/17	1,818,090.91	2	3,636,181.82	545,427.27	2	1,090,854.55	2
14	Компьютерын дэлгэц /Dell E2220HN/	2021/03/17	281,727.28	2	563,454.55	84,518.18	2	169,036.37	2
15	Зөөврийн компьютер /саарал Dell i7/	2021/10/12	3,181,727.27	2	6,363,454.54	954,518.18	2	1,909,036.36	2
16	Санхүүгийн програм Даймонд 5.0	2019/03/26	4,224,000.00	1	4,224,000.00	1,267,200.00	1	1,267,200.00	4

Д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтанд орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)		Цаашид ашиглах хугацаа /жилээр/
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	
17	Санхүүгийн програм Цалингийн систем	2019/04/08	2,266,000.00	1	2,266,000.00	679,800.00	1	4
	НИЙТ ДҮН			32	60,835,563.65 (жаран сая найман зуун гучин таван мянга таван зуун жаран гурван төгрөг жаран таван мөнгө)	18,250,669.10 (арван найман сая хоёр зуун тавин мянга зургаан зуун жаран есөн төгрөг арван мөнгө)	32	